болгох, практикт ШШГБ-ын албан хаагчдын аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт нэмэр болох нь дамжиггүй тул эрдэмтэн, судлаач та бүхэн энэ талаар анхаарч, цаашид сайжруулах талаар тодорхой бүтээл, судалгааны ажлууд хийгдэнэ гэдэгт итгэж байна.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн*
*811 дүгээр дамжааны сонсогч,*
*дэд хурандаа Д. Одхүү*

## ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЭРСДЛИЙН УДИРДЛАГА

Дэлхийн уур амьсгал мэдэгдэхүйц өөрчлөгдөж газар хөдлөх, үер ус буух, хүчтэй хар салхи гарах зэрэг гамшигт үзэгдэл, тэдгээрийн хор хохирол ихсэж, тоо давтамж нь олширч байна.

Газар хөдлөлт гэдэг нь дэлхий нийтийн хэмжээнд тохиолдож буй 40 гаруй байгалын аюулт үзэгдлийн нэг юм. Энэ утгаараа газар хөдлөлтийг Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль[1], болон 'Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөрөөр[2] гамшигт үзэгдэл болохыг нь тодорхойлсон билээ.

Судалгаанаас үзэхэд Улаанбаатар хотын газар хөдлөлтийн давтамж 50 жил байна. Хотын нийт барилгажсан талбайн 25 хувь нь 6 баллын, 52 хувь нь 7 баллын, 23 хувь нь 8 баллын бүсэд оршдог. Ийм нөхцөлд газар хөдлөлийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг эрс сайжруулах шаардлагатай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа хэд хэдэн төвлөрсөн хорих анги Улаанбаатар хотын бүсэд төвлөрөн үйл ажиллагаагаа явуулж байна. Дээрхи хорих ангиуд нь гол төлөв 1960-1970 аад оны үед тоосгоор баригдсан, эдэлгээний хугацаа дуусаж буй барилгуудтай байна.

Жишээлбэл: Хорих 401 дүгээр анги, насанд хүрээгүй хүүхдийн 411 дүгээр хорих ангиуд нь 1960-аас 1980-аад онд Хүүхдийн халдвартын больниц эмнэлэг ажиллаж байсан тоосгоор баригдсан, хуучирч муудсан барилгын тоонд багтдаг бөгөөд одоогийн нөхцөлд цаашид хорих ангийн барилга байгууламжийн зориулалтаар ашиглах боломжгүй тул түүний аюулгүй байдлын талаар анхаарал цаг болсныг харуулж байна.

[1]Гамшгаас хамгаалах тухай Монгол улсын хууль. [2003 оны 6 дугаар сарын 20-ны өдөр УИХ-аас баталсан].

[2] Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Их Хурлын 22 дугаар тогтоол [2011 оны 5 дугаар сарын 11-ны өдөр УИХ-аас баталсан].

Бусад хорих ангиуд хэдийгээр хожимхон баригдсан хэдий ч гол төлөв тоосго. блокоор баригдсан байдаг. Энэ нь Улаанбаатар хотод газар хөдлөсөн тохиолдолд асар их эрсдэл дагуулах нь ойлгомжтой.

Хоригдогч, ялтан, төрийн албан хаагч хэн ч бай Үндсэн хуулиар хамгаалагдсан амьд явах эрхтэй[1] бөгөөд энэ эрх нь газар хөдлөлтийн гамшгийн үед ямар нэгэн байдлаар зөрчигдөх болно.

Иймд Улаанбаатарын хотын бүсэд буй дээрхи хорих ангиуд нь өөр өөрсдийн нөөц. чадварт тулгуурлан гамшгаас урьдчилан сэргийлэх, газар хөдлөж гамшгийн аюулд өртсөн тохиолдолд хохирлыг богино хугацаанд арилгах чадавхийг бий болгож. олон хүний амь нас эд хөрөнгийг эрсдлээс хамгаалах нь чухал шаардлагатай байна.

Дээрхи эрсдэлтэй нөхцөл байдал нь энэ талаар дагнасан судалгаа шинжилгээний ажил явуулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Газар хөдлөлтийг байгалын аюулт үзэгдэл талаас нь олон нэр бүхий эрдэмтэд судалсан ба тухайлбал, П.Цэдэв[2] Д.Сэржмядаг[3] нарын цөөнгүй эрдэмтэн судлаачид судалж санал дүгнэлт, зөвлөмжөө гаргасан байдаг.

Гэвч хуулиар эдлэх ёстой зарим эрхээ хасуулан хорих ангид хуарагнан амьдарч, ял эдлэж буй ялтнууд, тэдний аюулгүй байдлыг ханган хамгаалж буй албан хаагчид аюулгүй байдлыг хэрхэн хамгаалах вэ? гэдэг асуулт өнөөдөр зүй ёсоор тавигдаж байна. Мөн хорих анги газар хөдлөлтийн аюул гамшгаас яаж урьдчилан сэргийлэх вэ?, Эрсдэлийг хэрхэн бага хохиролтойгоор даван туулах вэ?, Энэ асуудлыг шийдэж чадах арга зам нь юу вэ? гэсэн олон асуултуудад хариулт олохын тулд Улаанбаатар хотын орчимд байршиж үйл ажиллагаа явуулж буй төвлөрсөн хорих ангиудын хэмжээнд газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйлийг судлаж, газар хөдлөлтийн гамшигт үзэгдлийн үед хорих ангиудад ажиллаж амьдарч буй албан хаагч, ялтануудад үзүүлэх нөлөө, гамшгийн эрсдэл, гамшгийн эрсдэлийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг тодорхойлох, мөн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хорих ангиудын эрсдэлийн удирдлага зохион байгуулалтанд дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгүй болгох зарим арга замыг тодорхойлох, санал зөвлөмж боловсруулах зайлшгүй шаардлага тавигдаж байна. Мөн энэ талаар урьд өмнө ямар ч эрдэмтэн судлаачид дагнан судалж асуудал дэвшүүлж байсан бүтээл нийлэгдээгүй байгаа нь өнөөдөр бас л асуудал

[1] Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг 16 дахь заалт.“Хүн бүр амьд явах эрхтэй”

[2] *П.Цэдэв.* Гамшгаас хамгаалах мэргэжилтэн бэлтгэх сургалтыг боловсронгуй болгох асуудал. УБ. 2004.

[3] *Д.Сэржмядаг.* Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцооны өнөөгийн байдал. чиг хандлага. УБ. 2013.

болоод байна. Иймд энэ талаар дараах үндсэн асуудлыг дэвшүүлэн шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Улаанбаатар хот орчимд байршиж буй хорих ангиудад газар хөдлөлтийн гамшгийн үзүүлэх нөлөөг бууруулах, түүнтэй тэмцэхэд нэгдсэн зохион байгуулалтыг хангаж цаг алдахгүй шуурхай арга хэмжээ авах арга замын тодорхойлох;

2. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулахад удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ, хүчин зүйлсийг судлах арга зүйг боловсруулж гаргаж яаралтай хэрэгжүүлэх зэрэг ажлыг нэн тэргүүнд хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

Ингэснээр ШШГБ-ын анги, албадын эрсдэлийн удирдлага зохион байгуулалт боловсронгүй болох ба энэ талаархи санал зөвлөмж боловсруулж үйл ажиллагаанд нэвтрүүлснээр тэдэнд учрах газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл буурах, эрсдэлийг удирдах чухал ач холбогдолтой болох юм.